



НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2024 оны 06 сарын 13 өдөр

Дугаар 82

Улаанбаатар хот

Барилга акталж, нийслэлийн өмчийн
бүртгэлээс хасах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.11 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газрын баланст бүртгэлтэй 40,896,938.25 (дөчин сая найман зуун ерэн зургаан мянга есөн зуун гучин найман төгрөг хорин таван мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ, 18,403,622.22 (арван найман сая дөрвөн зуун гурван мянга зургаан зуун хорин хоёр төгрөг хорин хоёр мөнгө) төгрөгийн үлдэх өртөг бүхий хавсралтад заасан тус дүүргийн 1 дүгээр хорооны соёлын төвийн ашиглалтгүй барилгыг акталж, нийслэлийн өмчийн бүртгэлээс хасахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Х.Нямбаатар)-д зөвшөөрсүгэй.

2.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Эдийн засаг, төсвийн хороо (М.Халиунбат)-нд даалгасугай.

ДАРГА



Ж.БАТБАЯСГАЛАН

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2024 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн
82 дугаар тогтоолын хавсралт

АКТАЛЖ, НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛЭЭС ХАСАХ БАРИЛГА

№	Барилга байгууламжийн нэр	Ашиглал -тад орсон он	Байршил	Бүртгэлийн үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Акталж, данснаас хасах үндэслэл
1	Хорооны соёлын төвийн ашиглалтгүй барилга	1978	Налайх дүүрэг 1 дүгээр хороо	40,896,938.25	22,493,316.03	18,403,622.22	Нийслэлийн Хяналт шалгалтын газрын улсын ахлах байцаагчийн 2024 оны 02-13-01/027/42 дугаар дүгнэлт
НИЙТ ДҮН				40,896,938.25	22,493,316.03	18,403,622.22	